



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалт, тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тогтвортой амьжиргаа-3" төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 10 нэрийн, нийт 174,401,510.00 (нэг зуун далан дөрвөн сая дөрвөн зуун нэгэн мянга таван зуун арав) төгрөгийн балансын үнэ, 158,380,085.00 (нэг зуун тавин найман сая гурван зуун наян мянга наян тав) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг төслийн нэгжийн данс бүртгэлээс хасч, хавсралтад заасны дагуу орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, "Тогтвортой амьжиргаа-3" төслийн нэгжийн захирал Г.Золбоо, аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор тээврийн хэрэгслийг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг Орон нутгийн өмчит хуулийн этгээдэд эзэмшүүлэх, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001121
8-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
100 дугаар тогтоолын хавсралт

"Тогтвортой амжиргаа-3" төслийн нэгжийн данс бүртгэлээс хасч, орон нутгийн өмчид бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Бүртгэх хуулийн этгээдийн нэр
1	Зөөврийн компьютер	2017.08.07	21	2,030,338.48	42,637,108.00	42,637,108.00	-	21 аймгийн ОНӨГ
2	Проектор	2017.08.07	21	1,557,338.00	32,704,098.00	32,704,098.00	-	21 аймгийн ОНӨГ
3	Проекторын дэлгэц	2017.08.07	21	274,338.00	5,761,098.00	5,761,098.00	-	21 аймгийн ОНӨГ
4	Фото аппарат	2017.08.07	21	1,354,338.00	28,441,098.00	28,441,098.00	-	21 аймгийн ОНӨГ
5	Хэвлэгч хувилагч скан машин	2017.08.07	21	905,148.00	19,008,108.00	19,008,108.00	-	21 аймгийн ОНӨГ
6	Сургалтын сандал	2015.12.25	21	319,000.00	6,699,000.00	5,359,200.00	1,339,800.00	21 аймгийн ОНӨГ
7	Ширээ	2017.07.04	21	395,333.33	8,302,000.00	5,188,750.00	3,113,250.00	21 аймгийн ОНӨГ
8	Шүүгээ	2017.07.04	21	248,333.33	5,215,000.00	3,259,375.00	1,955,625.00	21 аймгийн ОНӨГ
9	Дугуйтай сандал	2017.07.04	21	558,333.33	11,725,000.00	7,328,125.00	4,396,875.00	21 аймгийн ОНӨГ
10	Номын шкаф	2017.07.04	21	662,333.33	13,909,000.00	8,693,125.00	5,215,875.00	21 аймгийн ОНӨГ
				210	8,304,833.81	158,380,085.00	16,021,425.00	
Нийт дүн				(хоёр зуу арав)	(нэг зуун далан дөрвөн сая дөрвөн зуун нэгэн мянга таван зуун арав)	(нэг зуун тавин найман сая гурван зуун наян мянга наян тав)	(арван зургаан сая хорин нэгэн мянган дөрвөн зуун хорин тав)	